

**УРАН БҮТЭЭЛИЙН АРГА, ТҮҮНТЭЙ ХОЛБОГДОХ
ЗАРИМ ХҮЧИН ЗҮЙЛС**

Д.Галбаатар¹

Зохиолчийн урлахуй үйлийн өвөрмөц барил, гүн ухаан- ертөнцийг үзэх үзэл, уран сайхны сэтгэлгээний хэв маягаас бүрэлддэг уран бүтээлийн аргын тухай онолын асуудлыг зохиолч бүр мэдэж байх албагүй нь ойлгомжтой. Зохиолчоос “ямар аргаар зохиолоо бичдэг вэ” гэж асуугаад ч тодорхой хариу авахад хэцүү ярвигтай онолын нийлэг асуудал юм. Гүн ухааны тодорхой үзэл баримтлалтай, ертөнцийг үзэх үзэл нь тогтож төлөвшсөн зохиолчийн уран бүтээлд аяндаа хуран цогцлож бүтээлээр нь дамжин илэрдэг онцгой үзэгдэл, ”олон зохиолчийн найруулгын адил төст нийтлэг шинжид хамаарагдах уран зохиолын хөгжлийн явцын ерөнхий шинж” /1/ “зохиолын уран сайхны хэлбэрийн гол зүйл” /2/-ийг уран бүтээлийн арга гэж үзэж байна.

Уран бүтээлийн арга нь нэг талаас тогтвортой, нөгөө талаасаа хувьсан өөрчлөгдөж байдаг зүй тогтолт хийсвэр ойлголт юм. Тэхээр уран бүтээлийн арга гэдэг зохиолчийн туурвил зүйд удаан хугацаагаар тогтвортой хадгалагддаг зүйл биш. Энэ нь уран бүтээлийн аргын нийтлэг хийгээд тогтворт шинжийг үгүйсгэж байгаа хэрэг биш юм. Тодорхой нэг уран бүтээлчийн хувьд бичиж туурвих арга, сэтгэлгээ нь нийгэм түүхийн өөрчлөлт, цаг үе, онцлог нөхцөл байдлаас шалтгаалан хувьсан өөрчлөгдөх үзэгдэл байнга гарч байдаг бөгөөд чухам энэ хувьсмал шинжийг хэлж байгаа юм. Ер нь уран бүтээлийн арга гэдэг ойлголт гадаад харьцаандаа /нийт туурвил зүйд/ харьцангуй тогтвортой үзэгдэл мөн.

Уран бүтээлийн арга хэмээх ойлголтын бүтцэд олон хүчин зүйл хамааралтай ч зохиолчийн гүн ухаан-ертөнцийг үзэх үзэл, уран сайхны сэтгэлгээний хэв маяг, уран бүтээх хувийн дадал чадварын нийлэг тогтолцоо гол тулгуур үндэс нь болдог. Зохиолчийн ертөнцийг үзэх үзэл гэдэг бол амьдралаас олсон мэдлэг туршлагадаа тулгуурлан өөрийн болгож авсан үзэл баримтлал, мэдлэг, ур дүйн цогцолбор юм. Тэр нь зохиолдоо барих зарчим, урлах хэв маяг, амьдралын олон талт үзэгдлүүдийн харьцаа хамаарлын учир шалтгааныг тайлан ойлгоход зохиолчид тусалдаг учраас Марксист онолчид уран сайхны сэтгэлгээний хэв маягийг “уран бүтээлийн аргын үндэс” гэж үзсээр иржээ. Л.И.Тимофеев “...нийгмийн тэмцэл, ертөнцийг үзэх үзэл, нийгмийн байр сууриараа бие биетэйгээ ойролцоо зохиолчдын уран бүтээлийн туршлагаас үүсэлтэй” /3/ гэсэн бол Г.Абрамович Н.А.Гуляев, С.Петров зэрэг онолчид “зохиолчийн ертөнцийг үзэх үзэл нь уран бүтээлийн аргын чухал бүрдэл хэсэг” гэж томъёолсон байна. Зохиолчийн ертөнцийг үзэх үзэл нь зохиол туурвилын агуулгыг бүрдүүлэн тодорхойлох, хэлбэр, зохиомж найруулгаа сонгон авахад нь зохиолчид аяндаа нөлөөлж

¹ ШУ-ы доктор, профессор. МУИС-ийн Монгол хэл, соёлын сургууль.

байдаг чухал хүчин зүйл мөн. З.Фрейд “ертөнцийг үзэх үзэл гэдэг бол бидний ахуйн бүх асуудлыг ямар нэг дээд саналгаас үндэслэн нэгэн байдлаар шийдвэрлэдэг оюуны бүтээц юм. Уг бүтээцэд нэг ч асуудал хариулагдахгүй үлддэггүй, харин ч бидний сонирхлыг татдаг биднийг тодорхой байртай болгож өгдөг зүйл” /4/ гэж үнэлж байв. Тэрээр гүн ухаан, шашин, урлаг, амьдралыг үзэх үзэл, хандлагуудыг судлан үзээд хүнд үнэмшил итгэлийн хэлбэрээр төлөвшин тогтсон үзэл санааны чиг баримтлалыг ертөнцийг үзэх үзэл гэж томъёолсон юм. Ийм үзэл К.Юнг, Э.Фишер нарын гүн ухаан, урлагийн онолын бүтээлүүдэд ч бий. Үнэхээр зохиолч бүтээл туурвихдаа өөрийн ертөнцийг үзэх үзлээ чөлөөтэй тавьж түүндээ захирагдаж байдаг учраас урлан бүтээх бүхий л процесст уг үзэл баримтлал аргын үндэслэл болох төдийгүй түүгээр тухайн зохиолын утга, агуулга, амьдралын үзэгдэл юмсад хандах зохиолчийн байр суурь, тусагдахууны мөн чанарууд тодорхойлогдон зохиолчийн үзэл санааны нийтлэг болоод зөрчилт талууд хурц тод илрэн гарч ирдэг ажээ.

Зохиолчийн уран сайхны өвөрмөц мэдрэхүй, авьяас билэг, бүтээн туурвих хувийн дадал зуршлын нийлэг тогтолцоо болох зохиолчийн уран сайхны сэтгэлгээний хэв маягийг уран бүтээлийн аргын бүтцэд хамааруулан авч үзэх шаардлагатай юм. Ертөнцийг үзэх үзэл нь тогтвортой байлаа ч гэсэн уран бүтээлч амьдралыг уран сайхны аргаар гүн гүнзгий дүрслэн үзүүлэх зорилтыг бүрэн шийдэх бололцоогүй. Ийм учраас зохиолчийн уран сайхны сэтгэлгээний хэв маяг хэмээх онолын түвшний ойлголтыг зайлшгүй ярих шаардлага гарч ирж байна. Энэ нь тухайн зохиолчийн гүн ухаан, ертөнцийг үзэх үзэл дээр бүрэлдэн бий болж цаашдаа зохиолчийн уран сайхнаар сэтгэх, туурвих хувийн туршлага, арга барил, найруулга төлөвшин тогтох үндэс суурь болдог чухал хүчин зүйл юм.

Уран сайхны сэтгэлгээний хэв маяг нь зохиолчид туурвих хүсэл буюу үүдэл санаа төрөх үе бүрт тэрхүү тодорхой хүсэл санааг бүрэн дүүрэн илэрхийлэх зорилгоор дүр, дүрслэлийг учир зүйн холбоо хамааралтай цогц бүтцэд шилжүүлэх урлахуйн бүтээлч үйл ажиллагааны явцад хуримталсан туршлагаар зохиолчийн өөртөө бий болгосон туурвил зүй, ур чадварын стандарт чанар гэж тодорхойлж болох юм. Уран сайхны сэтгэлгээний нийтлэг хэв маягуудыг эртнээс ерөнийд нь реалист, реалист бус хэв маяг /мөн романтик хэв маяг/ гэж ялган үзсээр иржээ.

Дэлхийн уран зохиолын практикаас үзэхэд реалист, реалист бус хэв маягууд уран сайхны туурвил зүйн практикт зэрэгцэн оршиж, өрсөлдөн хөгжих явцдаа өөр өөр шинэ хэлбэршлүүдийг бий болгож, бас орхиж гээсээр иржээ. Аливаа үндэстний уран зохиолд нэг үе реалист, нөгөө үе реалист бус хэв маяг давамгайлах, эс бөгөөс хөгжлийн тодорхой түвшинд саармагжин нийлэгших, эсвэл хэт туйлширсан хандлагууд /софистик/ үүсч нэг үе натуралист, нөгөө нэг үе абстракционист гэх мэт сэтгэлгээний өөр өөр хэв маягууд бие биеийг халж солих нь ердийн үзэгдэл юм. Мөн хэт улс төржсөн чанад дэглэмтэй нийгмийн орчинд урлагт социалист реализм гэх юмуу уламжлал шинэчлэлийн зохист харьцааг хэт үгүйсгэсэн модернизм зэрэг сөргөлдөгч хэв маягууд үүсдэг. Тэдгээр нь тус тусдаа бие даасан уран сайхны сэтгэлгээний хэв маяг болох урсгалууд /сюрреализм, дадаизм, абсурдизм г.м/-ыг төрүүлж байдаг. Зүй нь алив уран бүтээл бодотой, мөн хийсвэр байх зүй зохист диалектик харьцаа урлагийн оршихуйн үндэс мөн. Бидний одоо ч салангид үзсээр буй реализм ба реалист бус арга, тогтолцооны аль алин нь /зарим нэг хэт урсгалуудыг эс тооцвол/ бодотой ба хийсвэр байх үндсэн хоёр зарчмаас тийм ч их холдон тасарч чадаагүй байгаа нь үүнтэй холбоотой билээ.

Реализмын бодотой, реалист бус аргын хийсвэр байх зарчмуудыг хэт туйлчлан үзэх нь урлагт зайлшгүй олон урсгалыг бий болгож, эерэг сөрөг үр дагаврууд гарч ирдэг. Реалист бус уран сайхны сэтгэлгээний хэв маяг нь уран бүтээлийн субъектив тал буюу аж байдлыг хэвийн байдлаас нь өөр дүрс, загварчлалд шилжүүлэх, хийсвэрлэх аргаар хэлбэрийн өөрчлөлтүүд хийн болзолт дүр, дүрслэл, оюун санааны зүйлсийг уран бүтээлч хайн олж, өөр өөрийн сэтгэлгээний онцлог, туйлын хүслэнд захируулах гэсэн чөлөөт эрэл сэтгэлгээний үр дүн болж үүсчээ. Уран сайхны сэтгэлгээний эрт үед реалист болон реалист бус хэв маяг нь гол төлөв уран бүтээлд нийлэг хэлбэрээр оршиж тодорхой зохиол бүтээлд нэг нь голлож, нөгөө нь дагалдах харьцаанд орчин оршиж, харилцан нэг нь нөгөөгийнхөө оршихуйн үндэс болж байж. Өөрөөр хэлбэл реалист хэв маяг уран бүтээлийн дүрийн объектив шинж, реалист бус хэв маяг бодол санаа буюу субъектив хүчин зүйлсийг урлагт ашиглах бололцоог нээж өгсөн ажээ. Энэ тогтвортой, нэгдмэл байдал нь цаашдаа хүн-нийгмийн хөгжлийн хүчин зүйлийн нөлөөгөөр эвдэрч, харьцаа алдагдан XIX-XX зууны үе гэхэд хэт реалист уран бүтээлчид ахуйг /фотографизм ба биологизмаар илэрдэг Д.Г/ хэтрүүлэн үнэлснээр натурализм, оюун санааны хийсвэрлэлийн үүргийг хэтрүүлэн өргөмжлөх үзэл онолын нөлөөгөөр абстракционизм сюрреализм гэх зэрэг хэт урсгал, зориудын уриа тунхаг бүхий өч дөчнөөн дэг сургуулиуд үүсчээ. Эдгээр урсгалууд ч анхнаасаа реализмтай мах цусны барилдлагатай байсан билээ.

Нэр цуутай зохиолчид өөр зуураа давтагдашгүй бодгалиуд байж өөр өөрийн урлан бүтээх хувийн өвөрмөц арга, найруулгыг бүрдүүлдэг зүй тогтолтой хэдий ч уран зохиолын онолд уран бүтээлийн арга гэдэг ойлголтыг үүнээс хавьгүй өргөн хүрээнд авч үздэг. Зохиолч бүр өөрийн өвөрмөц онцлог барилтай байдаг ч үзэл санаа, амьдралын асуудлыг дүрслэхдээ баримталдаг зарчим, дүр бүтээх арга, сэтгэлгээ, дүрслэлийн хэв шинжээрээ өөр хоорондоо ижил төсөө бүхий хүрээ үүсгэж байдаг. Үүнээс шалтгаалан уран зохиолд олон зохиолчийг өөртөө хамруулан авдаг урсгал, чиглэл хэмээх онолын ойлголтууд гарч ирдэг. Ийнхүү зохиолчид, тэдний зохиолууд үзэл санаа, гоо зүйн талаар нийтлэг шинжийг /санаатай, санамсаргүйгээр/ олж, тэрхүү чанар нь уран бүтээлд илэрч буйг онол судлалд уран бүтээлийн арга хэмээх ойлголтоор төлөөлүүлдэг.

Уран зохиолын түүх бол олон арга бие биеэ халж сольж, тэмцэлдэж ирсний үр дүн мөн. Тийм ч учраас зохиолчид аргаасаа шалтгаалан уран сайхны сэтгэлгээний янз бүрийн хэв маяг, урсгалд хуваагддаг байна. Чухам реалист хэв маягийг домог зүйн, шүүмжлэлт, сэргэн мандлын, шинэ реализм, социалист реализм гэх, реалист бус сэтгэлгээний хэв төрхийг абстракционизм, натурализм, сентиментализм, символизм, романтизм... бусад тодорхой тунхаг бүхий дэг сургуулиудад хувааж буй нь тус бүрдээ уран бүтээлийн нэгдмэл нэг ерөнхий аргад хамааралтайн шинж гэж үзнэ.

Э.Золя, Ч.Диккенс /натуралист/, Ж.Байрон, В.Хюго, А. Мицкевич /романтист/, Д.Нацагдорж, М.Горький, А.Дюма, /реалист/, Ф. Кафка, Ж.Жойс, М. Пруст, А. Рембо, Ж.П. Сартр /модернист/ аргатай учраас л уран бүтээлийг нь нэгэн нийтлэг айд хамруулан үздэг билээ.

Уран бүтээлийн аргын бүтцийн өөр нэг чухал бүрдэл хэсэг бол зохиолчийн найруулга юм.

Уран бүтээлийн арга нь нэг утгатай ойлголт биш, орон зайн төдийгүй цаг хугацааны түвшинд өргөн дэлгэр агуулгатай. Хэрэв найруулга болоод уран сайхны аргын хоорондын дотоод амьд холбоог орхигдуулбал "арга" гэдэг ухагдахууны мөн

чанар илрэх бололцоо хязгаарлагдана. Иймд уран бүтээлийн "арга"-тай хамт найруулгын асуудлыг авч үзэх хэрэгтэй болно.

Зохиолчийн найруулга нь бүтээн туурвих үйл явц, сэтгэлгээний хэв маяг, эрлийн үр дүнд арга зүйн хуримтлал бий болсноор зохиолч бүрд өвөрмөц байдлаар төлөвшдөг бичлэг, сэтгэлгээ, ур чадвар, туршлагын онцлог шинж болно. Өөрөөр хэлбэл зохиолчийн үзэл санааны чиглэл, урнаар сэтгэж туурвих онцлог, уран сайхны шийдэлтүүдийн үр дүнд бий болдог зохиолын утга санааны цогцолбор, хэлбэрийн зохист илэрхийллүүд болон өгүүлэгдэхүүн, дүрслэх хэв маяг, хэлийг ашигласан байдал зэрэг олон талыг хамарсан нийлэг ухагдахуун юм. Найруулга ямар нэгэн бэлэн зэлэн зүйл биш, нэг талаас бүтээн туурвих явцад зохиол бүтээлд аяндаа хуралдан цогцолж байдаг, нөгөө талаас зохиолчийн арга барил, сэтгэмж, дүрслэлийн хэв маяг, хэлийг ашиглах эв дүйн тогтвортой давтамжаар бүрэлдэж тогтдог зүйл. Товчоор хэлбэл зохиолчийн хуримтлуулсан хувийн арга туршлага, бичлэг, сэтгэлгээний дахин давтагдашгүй онцлог юм. Уран зохиолын онолд найруулгыг хэд хэдэн утгаар хэрэглэдэг. Үүнд: I. зохиолчийн хувийн найруулга,

II. урсгал, чиглэл, дэг сургуулийн найруулга,

III. тодорхой үндэстний уран зохиолчийн нийтлэг найруулга

IV. зохиол нэг бүрийн найруулга гэх ойлголтын хэд хэдэн түвшин бий.

Уран бүтээлийн найруулгыг монгол онолчид янз янзаар тайлбарлаж иржээ. "Уран сайхны сэтгэлгээний нэг хэв маяг дээр үндэслэж, үзэл бодлын адил, хэрэв адил биш бол түүний нэлээд хэдэн гол шинж нь өөр хоорондоо төсөөтэй чанартай дэгийг найруулга гэнэ" /С.Байгалсайхан./, "... зохиолчийн зохиолуудын сэдэв, утга санааны чиглэл, байгууламж, үг хэлний зэрэг бүх зүйлд онцлог болон тусгагдах зохиолчийн үзэл санааг, уран сайхны бүхий л онцлогийн цогцолборыг "зохиолчийн найруулга" /5/ гэнэ хэмээн тайлбарлажээ.

Р.Уоллек, О.Уоррен нар найруулгыг өргөн утгаар нь "Найруулга гэдэг бол уран илтгэх урлаг хийгээд уран зохиолын хүрээг бүхэлд нь хамраад зогсохгүй хэлний бүх хүрээний өвөрмөц шинжтэй утга төгөлдөр байх ерөнхий зорилгод нэгдсэн бүх аргуудын тогтолцоо буюу зарчим юм. Найруулга зүй гоо сайхны ухагдахууныг илтгэсэн эсэхэд гол анхаарлаа хандуулсан тохиолдолд л уран зохиолын нэг хэсэг болно" /6/ гэсэн бол "хөгжлийн явцад бичгийн зүйлсийн хэв маяг, өгүүлэн ярих, бүтээн туурвих үйлийн өвөрмөц давтагдашгүй шинжүүд"-ийг /7/ нэгтгэн найруулга хэмээх нийтлэг ойлголтыг бий болгожээ гэж үзжээ.

Уран бүтээлийн найруулгын асуудлыг хэт жижигрүүлэн саармагжуулж, эрээвэр хураавар зүйлийн цуглуулга мэтээр ойлгодог тал бий. Найруулгыг хоёр түвшин, харьцаанд авч үзэх шаардлагатай. Нэгдүгээрт олон зохиолчийн бүтээлийг хооронд нь харьцуулахад үл давтагдан ялгарч буй онцлог шинжийг зохиолчийн хувийн найруулга буюу тухайн нэг бүтээлийн найруулгын онцгой тал гэж үзэх, хоёрдугаарт хэсэг бүлэг хийгээд олон зохиолчийн уран бүтээлд нийтлэг давтагдаж байгаа шинжээр нь урсгал, чиглэл, янз бүрийн дэг сургуулийн найруулга гэж тодорхойлох нь зохистой юм. Арга, найруулга хоёрыг нэг зүйл гэж шууд адилтгах эсвэл огт өөр ойлголтууд гэж салгахаас гадна, "аргын бүрэлдэхүүн" гэж үздэг үзлүүд ч бий. Найруулга нь уран бүтээлийн аргын технологийн талыг бүрдүүлэгч гол хүчин зүйл мөн.

Зохиолчид өөр өөр газар оронд, онд ондоо цаг үед төрж өсч, туурвиж бүтээж байдаг ч өөр хоорондоо санамсаргүйгээр найруулгын ижил хэв маягтай болох нь бий. Ийнхүү өөр өөр газар нутаг, он цагт төрсөн зохиолчдын найруулгын төсөөт шинжүүд

тодорхой, урсгал юмуу чиглэлийн найруулгыг бүрдүүлдэг. Энэ нь уран бүтээлийн арга, найруулга хоёр амин холбоотойг улам тодорхой болгож байна. Дорно дахины уран зохиолын найруулга баялаг уламжлалтай Дандин "Зохист аялгууны толь" /МЭ ҮІ-ҮІІ зуун/ алдарт бүтээлдээ Вайдарбха, Гаудия /8/ хэмээх хоёр гол арга, найруулга бийг хэв шинж үүргийн талаас нь нарийн ялгаж тайлбарласан юм.

Уран бүтээлийн арга харьцангуй тогтвортой, нийтлэг шинжтэй бол найруулга нь зохиолч бүрд өөр өөрөөр илэрдэг зохиолчийн технологийн тогтсон горим шинжтэй. С.Байгалсайхан, найруулга нь "уран сайхны сэтгэлгээний нэг хэв маяг дээр үндэслэдэг" гээд "найруулгын хүчээр бид зохиолчдын амьдралыг уран сайхнаар дүрслэн үзүүлэх уран бүтээлийн аргыг тодорхойлж чадна". /9/ гэж үзсэн нь зөв юм. Үнэхээр уран бүтээлийн арга, найруулга хоёр хоорондоо олон талын холбоо хэлхээнд орших боловч ерөнхийдөө найруулга нь зохиолчийг тодорхой арга барил сонгоход нь туслаж, харин арга нь зохиолчийн гүн ухаан, ертөнцийг үзэх үзэл, гоо сайхны эрмэлзлэлийг тодорхойлох харьцаанд оршино. Энэ нь найруулга хувирамтгай төдийгүй нэг арга бүхий зохиолч өөр өөр найруулгыг сонгон ашиглах боломжтой гэсэн үг юм. Ямар ч зохиолч зохиол бичихдээ:

I. үйл явдал, үзэгдэл санааг дүр дүрслэлд шилжүүлэх,

II. бодот байдлын нийтлэг ерөнхий зүй тогтлыг үзэгдлийн хэлбэрт шилжүүлэх урлагийн үндсэн хуулиудыг мөрдлөгөө болгодог. Эдгээр шинжүүд нь найруулгын ерөнхий хэв маягийг тодорхойлох төдийгүй реалист болон реалист бус дүрслэл, сэтгэлгээний хэв маягийг тодорхой болгож өгдөг.

Иймээс уран бүтээлийн аргыг бүтээн бүрэлдүүлэгч нэг гол хүчин зүйл найруулга юм. Найруулгаараа ялгарна гэдэг тухайн аргын өвөрмөц шинжийг ямар нэг хэмжээгээр илэрхийлж байна гэсэн үг. Нэг үгээр хэлбэл уран бүтээлийн "бүх элементүүд өөр хоорондоо нэгдмэл байдлаар оршиж буй тогтолцоо" -г найруулга гэж болно. Харин найруулгыг зохиолын, тодорхой нэг арга ба чиглэлийн хүрээнд авч үзэж болохоос гадна уран бүтээлийн арга бүр бие даасан нийтлэг найруулгатайг мартаж болохгүй. Арга, найруулга хоёр бие биеийг тодорхойлогч харьцаанд оршино. Л.И.Тимофеев уран бүтээлийн аргыг "арга ба чиглэл", "арга ба найруулга" гэсэн хоёр хэсэгт бүлэглэж үзсэн нь /10/ үүнтэй холбоотой билээ.

Орчин үеийн хэлбэр судлалын болон монгол онолчдын дүгнэлт нилээд талаараа ижил төсөөтэй болохыг бид харж байна. Уран бүтээлийн арга ба найруулга нь үлэмж нэгдмэл шинжтэй боловч өөр өөр ойлголтыг төлөөлдөг. Найруулга уран бүтээлийн дээд шалгуур боловч уран сайхны чанарын түвшин, бүтцийг илэрхийлэгч биш. Харин уран сайхан чанарын оршин байгаа хэлбэр юм. Найруулгад зохиолчийн уран сайхны практик үйл ажиллагаа төдийгүй тухайн уран бүтээлч өөрийн дэвшүүлсэн асуудлыг уран бүтээлдээ хэрхэн шийдсэн тухай хариултууд ч хамаарч байдаг.

Товчдоо уран бүтээлийн арга гэдэг бол зохиол бүтээлд барих ерөнхий зарчмуудын тогтолцоо, харин найруулга нь тэдгээр зарчмууд туурвил зүйд хэрхэн хэрэгжсэн байдлын илрэл шинжтэй гэж хэлж болно. Уран бүтээлийн арга нь зохиолчид баатруудаараа дамжуулан амьдралын үзэгдэл явдалд хэрхэн хандах үзэл санааны чиглэлийг бүрдүүлж өгдөг бол зохиолч найруулгаараа дамжуулан тэрхүү гол үзэл санааны биелэл болсон урлагийн өвөрмөц орчинд төрсөн хүн буюу уран дүрийг амилуулж өгдөг. Найруулгад зохиолчийн авъяас билигийн хэр хэмжээ, хувийн давтагдашгүй бодгаль шинж тод илэрдэг бол аргад ойролцоо туурвил зүй бүхий бусад зохиолчидтой тухайн зохиолчийг ойртуулсан илүү ерөнхий шинжүүд /ертөнцийг үзэх

үзэл, гоо зүйн хандлага гэх мэт/ нь илэрч байдаг. Үүнээс үзэхэд уран бүтээлийн найруулга нь арга гэдэг ойлголтоо өөртөө агуулдаг төдийгүй тухайн уран бүтээлийг түүх, уран зохиолын хүрээ рүү татан ойртуулж уран сайхны үйл явцтай холбож өгдөг нь маргаангүй байна.

Уран бүтээлийн арга хэмээх ойлголтын бүтцийн чухал бүрдэл хэсэг бол уламжлал, шинэчлэлийн асуудал болно. Эдгээр хос ойлголтыг бие биеэс нь салгах боломжгүйтэй адил уран бүтээлийн арга гэдэг ойлголтоос ангид үзэх боломжгүй юм. Түрүү үеийн урлагийн үнэт бүтээлүүд дараа үеийн бүтээл туурвилтай олон талын амин шүтэлцээтэй байдгийг уламжлал гэдэг. Гэтэл тэрхүү уламжлалууд дараа дараагийн зохиолч уран бүтээлчдийн туурвилд ямар нэг байдлаар /арга, найруулга г.м/ шинэчлэгдэн баяжих үзэгдлийг уран зохиолд шинэчлэл гэнэ. Тэхээр уламжлал гэдэг нь түрүү үеийн шинэчлэл, харин шинэчлэл нь түүхэн тодорхой үеийн үр бүтээл болж гараад цааш үргэлжлэх уламжлал гэсэн агуулгаар хэрэглэгддэг байна.

Уламжлал шинэчлэл хоёр үл салах нэгдэлтэйн хамт уламжлал нь нэлээд тогтвортой шинж бүхий байдаг бол шинэчлэл нь илүү хувьсамтгай шинжтэй. Шинэчлэл үндсэн хоёр хэлбэрээр явдаг.

Нэгдүгээрт, урлагийн хөгжлийн зүй тогтол ёсоор алгуур аажим тасралтгүй шинэчлэгдэн хувьсах. Хоёрдугаарт, цаг үе, нийгэм, улс төр, эдийн засгийн өөрчлөлт, хямралт нөхцөл байдлыг даган урлагт эрчимтэй шинэчлэл явагдах нь бий. Ийм үзэгдэл XIX-XX зуунд өрнө дахины урлагт капитализмын эдийн засгийн хямрал, дэлхийн I, II дайны үйл явцыг дагасан сэтгэл зүйн өөрчлөлт, хямралт байдлыг дагалдан гарч байлаа. Уламжлал харьцангуй тогтвортой шинж бүхий боловч уран бүтээлийн үзэл санаа, дүр, зохиолчийн сэтгэх маяг, дүрслэх арга, хэл найруулга түүнчлэн төрөл зүйлийн өөрчлөлт баяжилт, уран сайхны дүрслэлийн хэлбэрүүдээр дамжин байнга хувьсан шинэчлэгдэж баяжиж байдаг үзэгдэл. Шинэчлэл нь уран зохиолд урсгал байдлаар тогтвортой явагддаг үзэгдэл боловч нэлээд тохиолдолд гэнэтийн байдлаар идэвхжиж нэг аргыг нөгөөгөөр солих, эсвэл хуучин арга задарч олон урсгалд хуваагдан улмаар хуучны өв уламжлалыг эрс үгүйсгэн илтэд өөр хэв шинж бүхий арга, найруулгыг дэвшүүлэх нь бий. Гэхдээ шинэчлэлийн аль ч хэлбэр байсан уран бүтээлчид өмнө үеийн үртэй туршлага, өв, үнэт зүйлсээс сорчлон авч цааш уламжлан хөгжүүлдэг.

Энэ тухайд XX зууны шинэ философи /экзистенциализм/-ийн томоохон төлөөлөгч Н. Бердяев /1874-1948/ "Бид хуучин утга зохиолыг шүтэж өнгөрснийг баримтлах үзлийн гүн нарийн утгыг өдгөө хүртэл нааштай авч үзсэнгүй. Алив салбарт хэт хуучныг баримтлах нь шинэчлэл, ирээдүйн эсрэг үйлдэл бөгөөд хуучин уламжлалаа эсрэгээр гуйвуулах аюултай. Гэхдээ утга зохиолд хуучныг баримтлагч хүчтэй бүлэглэлгүйгээр утга зохиол хэвийн, эрчимтэй, эрүүл саруул хөгжиж чадахгүй үнэнийг нуух хэрэг алга" /11/ гээд "Хуучныг шүтэх үзэл бол оюун санааны хувьд гүн гүнзгий, амьдралын эртний өв сурвалж тийш хандсан бат бэх үндэстэй. . . өмнөх үе ирээдүйгээс хэрхэвч дутахгүй эрхтэй" /мөн тэнд/ гэж үзэж байв. Үнэхээр уран зохиолын уламжлал шинэчлэлийн асуудалд хандахдаа хам цагийн судалгаанаас цуваа цагийн судалгаа илүү ач холбогдолтойг бодох ёстой. Хуучин уламжлалт үзэл, арга барил нь улирах цагийн хэлхээ холбоосыг тэтгэн ирээдүйг өнгөрч улирсантай холбож өгдөг төдийгүй урлагийн шинэчлэлийн эхэн үеийн гэнэн хөөсөрхөг /сэтгэл хөдлөлийн/ хөдөлгөөнийг ямар нэг хэмжээгээр өөрийн хүч, хараан дор тодорхой хугацаанд барьж түүний хөгжлийн зөв зүг чигийг тодорхойлох бололцоо олгодоогоороо уран зохиол хийгээд түүний судлалд ихээхэн тус үзүүлж чиг баримжааг тодорхойлж өгдөг.

Аль ч үеийн соёл, уран зохиол хуучны зүйлээс эхтэй. . . тэрхүү хуучин эхлэл нь туйлын зоримог бүтээн туурвих үйлс байлаа ч түүнд хор, тээг саад болох ёсгүй юм. Н.Бердяевын үзлээр "хуучин үүтгэл хийгээд бүтээлч үүтгэлийн аль аль нь хуучныг сахин хамгаалж, шинийг санаачлан бүтээхийн эхлэл байх ёстой. Хэрэв энэ хоёр эхлэлийн аль нэг нь дангаар ноёлож, нөгөөгөө шахан зайлуулбал соёл мөхөх /мөн тэнд/ учиртай гэсэн нь монголын орчин үеийн уран зохиолын судалгаанд арга зүйн ач холбогдолтой билээ.

Социализмын үеийн уран зохиол нь нийт утга зохиолын өв туршлагыг бус зөвхөн "дэвшилтэд ардчилсан" соёлын уламжлалыг ялган авснаас социалист реализмын түүхэн хувь заяанд хортой нөлөө үзүүлсэн билээ. Америкийн нийтлэгч, судлаач Джеймс Фаррел /1904-1979/ "Америк дахь уламжлал" /1953/ өгүүлэлдээ "Уламжлал гэдэг бол хүн төрөлхтний туршлага мөн. Уламжлал бол халин одогсдоос одоо энх тунх амьдарч байгаа хүмүүст олон янзын замаар шилжин ирсэн зүйлсийн цогцлол байдаг. . . Хүний бодол санаа, сэтгэл хөдлөлийн өвөрмөц илрэл болдог зан байдлын дадал заншил, маяг байдал ч гэсэн бас уламжлалаас үүсэлтэй. Тэгэхээр уламжлал нь өнгөрсөн үеийн ололт, дэвшил, үйл ажиллагааны үлгэр загвар, туурвин бүтээх, зохион байгуулах ажил, хэл яриа, сэтгэлгээнд хамаатай" /12/ гэж үзэж байв.

Үнэхээр уламжлалын уг сурвалж нэг үеэс нөгөөд шилжих явцаар илрэх бөгөөд энэ нь зөвхөн нэг үндэстэнд хамаарах үзэгдэл биш билээ. Уламжлал нь нэг үеийнхнийг өмнөхтэй нь, нэг улс орныг нөгөөтэй нь, нэг үндэстнийг өөр нэг үндэстэнтэй, нэг эрин зууныг дараагийн эрин зуунтай, нэг арга найруулгыг өмнөх ба өөр бусдынхтай, нэг уран зохиолыг өөр нэгэн үндэстний уран зохиолтой холбож өгдөг нийт хүн төрөлхтөний туршлага юм. Энэ нь монгол аман ба сонгодог /шашин, иргэний гэх мэт/ бичгийн уран зохиолыг монголын орчин үеийн уран зохиолтой, тэрчлэн өөр улс үндэстэн, бүр нийт хүн төрөлхтөний уран сайхны соёлын ололт, үе шат, бүтээн туурвисан түүхэн туршлагатай холбон судлах асар их бололцоог нээж өгөх юм.

Урлаг судлаач А.Сохор "Уран сайхны арга нь амьдралын дүгнэлт, үзэл бодлын чиглэл, түүний тогтолцоо байх төдийгүй уран бүтээлчид шинэ үзэгдэл бүхнийг эрж хайх, урлагийн шинэ цаг үеийн дүр төрхийг судлах, шинэчлэлт хийхэд нь тусладаг. Энэ бол хуучны эсрэг шинж нь юм. Дашрамд хэлэхэд тохиолдлын юм шиг тухайн эсрэг шинж бүхэн /классицизмийг халсан романтизм, романтизмыг халсан реализм г.м/ дээрх зүй тогтлыг агуулж уран бүтээлчийн ертөнцийг үзэх үзэл туурвил зүйн туршлагаар илэрхийлэгдэж байдаг" гээд цааш арга өөрчлөгдөхөд "нэг тохиолдолд агуулгын аль нэг тал өөрчлөгдөж нөгөө тохиолдолд өөр нэг тал нь өөрчлөгдөнө. Ийм учраас классицизм ба романтизм, романтизм ба реализм цөмөөрөө хоорондоо эрс хатуу зааглагдсан гэж үзэх аргагүй" /13/ гэжээ. Өөрөөр хэлбэл уран бүтээлийн нэг аргаас нөгөө аргад шилжих явцад туурвил зүй бүхэлдээ бүр мөсөн өөрчлөгддөг гэсэн үг биш харин зохих хэсэг нь шинэчлэгдэж, өөр нэг хэсэг нь уламжлагдан хоцордог зүй тогтлыг хэлжээ. Энэ нь нэг зохиолч хэд хэдэн арга, найруулга бүхий байх бололцоог олгодог. XX зууны эхэн үеийн шинэ философи-гоо зүй-урлагийн хөдөлгөөн болох модернизм хуучин, шинэ хоёрын халз тулааны зааг дээр үүсч дотроо өдий төдий урсгалд хуваагдсан билээ. Үүнийг асар удалгүй өөрийгөө үгүйсгэх мөн бие биеэ богино хугацаанд халж сольсон өөр өөр шинэ үзэгдлүүд түрэн гарч ирсэн билээ. Гэвч XX зууны 80-аад оноос дахин нэгдэх үйл явц идэвхжиж модернизмын суурь дээр постмодернизм шинэ өнгө төрхөөр мэндэлсэн билээ. Гэсэн хэдий ч энэхүү халаа солио бүхий хөгжлийн явцад зөвхөн сонгодгууд

шалгаран үлддэг нь түүний дотоод жам хууль, уламжлал шинэчлэлийн эцсийн үр дүн болж үлддэг байна.

Уламжлал шинэчлэл нь уран бүтээлийн арга, урсгал чиглэлд хамаатайн адил уран бүтээлийн бодот ба бодот бус арга сэтгэлгээ нь урлаг уран зохиолын зүй зохист хөгжлийн уламжлал, шинэчлэлийн үйл явцын бодот үр дагавар мөн. Чухам ийм шинэчлэл хийх нийгэм, түүхийн таатай нөхцөл монголын орчин үеийн уран зохиолд 1921, 1960-аад оны эх, 1990-ээд онд тохиолдож байсан юм.

Уран сайхны арга гэдэг ойлголтын хүрээнд уран бүтээлийн найруулга урсгал, чиглэл, уламжлал, шинэчлэл зэрэг урлагийн онолын тодорхой ойлголт үзэгдлүүд хамаарагдаж байдаг тухай бид товч авч үзлээ. Энэ талаар судлаач К. Гизатов "Энэ бүхнээр дамжин уран бүтээлийн хэм хэмжээ хийгээд уран бүтээлчийн өөрийгөө илэрхийлэх эрх чөлөө илэрч байдаг. Уран сайхны аргын бодот ололт нь ахуйн болон оюун санааны бодот байдлыг тусгах уран сайхны нарийн бөгөөд олон талт асуудлыг тайлбарлах түлхүүр болдог. Өөрөөр хэлбэл шүүмжлэлт реализм, романтизм, классицизм аль нь ч байлаа гэсэн тухайн тодорхой аргын онцлогийг нээх түлхүүр . . . " /14/ гэжээ.

Зохиолчид юм үзэгдэлд хандах, ойлгон ухаарах түүнийг дүрслэх, хэлбэржүүлэн илэрхийлэх аргаасаа шалтгаалан уран сайхны сэтгэлгээний янз бүрийн хэв маягийг бий болгожээ. Чухам модернизм, реализм, формализм, абстракционизм, символизм, сентиментализм, имперессионизм, натурализм гэх юмуу эсвэл бодот ба бодот бус арга хийгээд тодорхой дэг сургуулиудад хуваагдан ялгарч байгаа нь тус бүрдээ уран бүтээлийн өвөрмөц аргууд болохыг харуулдаг ч ерөнхийдөө нэгдмэл нэг аргад захирагдаж байгаагийн шинж юм. Уран бүтээлийн аргын тухай ойлголт, түүний бүтэц ийнхүү олон хүчин зүйлсээр тодорхойлогддог ярвигтай нийлэг асуудал билээ.

Уран бүтээлийн аргыг зохиолчийн үзэл санааны үндэслэл болон зорилго, түүнийг хэрэгжүүлэх хэлбэрээр нь ийнхүү бодот ба бодот бус хоёр хэв маяг, аргын тогтолцоонд хуваан үзсээр ирсэн түүхтэй байна.

Номзүй

1. Гаадамба Ш. "Уран зохиолын онолын үндэс" УБ.1989. 231-р тал
2. Эльсберг. "Индивидуальные стили и вопросы их методико-теоретического изучения". В кн: "Теория литературы". М.1965 стр 35
3. "Основы теория литературы" М. 1973 стр 87,89
4. Фрейд.З. Введение психоанализа и лекций М.1989
5. Гаадамба Ш. "Уран зохиолын онолын үндэс". УБ. 1989. 226-р тал
6. Уэллик Р. Уоррен О. "Уран зохиолын онол". УБ. 1998. 112-р тал
7. Сампилдэндэв Х. "Монголын яруу найргийн товчоон".УБ. 1996
8. Дандин. "Зохист аялгууны толь". ШУА.УБ. 1988.48-р тал
9. Байгалсайхан С. "Уран зохиол шинжлэлийн удиртгал".УБ. 1995. 113-р тал
10. Тимофеев.Л.И. Основы теория литературы.М.1976. 109
11. Бердяев.Н. Тэгш бус байдлын философи: "Нийгмийн философийн талаарх өстөнд чиглэсэн захидал".Берлин. 1923. "Бодрол бясалгал" сэт. 1994. 22-р тал
12. Дж. Фаррел "Америк дахь уламжлал", "Бодрол бясалгал" сэт. 1994

13. Сохор А. "Стиль, метод, направление". В.сб. Вопросы теории эстетики и музыки. Вып.Ч.Л. 1965.стр 86
14. Гизатов К. "Статьи и мысли об искусстве". М. 1936

SUMMARY

The author analyzes the artistic method of the literary work. Method of the literary work can be divided into realistic and non-realistic types and system of methods according to author's objective and basis of idea. Literary work can be identified by the tradition and innovation, the world view, the artistic style and the philosophical doctrine.